



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/118

Булган сум

**“Хойд бүсийн ахмадын чуулга уулзалт-2026”-д
оролцох ахмад настнуудад дэмжлэг үзүүлэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.10, 14 дүгээр зүйлийн 14.5.2, 14.5.3 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны XII хуралдааны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2026 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай” А/97 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ахмад настны хөдөлмөр эрхлэлт, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн халамж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарт тулгамдаж буй асуудлыг бүсийн хэмжээнд хэлэлцэж, саналыг нэгтгэх зорилготой “Хойд бүсийн ахмадын чуулга уулзалт” Орхон аймагт 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулагдах тул тус чуулганд оролцогчдын аюулгүй байдлыг ханган, идэвх санаачилгатай оролцохыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга (Н.Батжаргал)-д үүрэг болгосугай.

2. Чуулганд оролцогчдод шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталж, 499,400 (дөрвөн зуун ерэн есөн мянга дөрвөн зуу) төгрөгийг 2026 оны Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээг хэрэгжүүлэх зардлын, Ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулах, хөгжил оролцоог дэмжих арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2026 оны
06 дугаар сарын 10-ны/ний өдрийн
А.Т.Н.18 дугаар захирамжийн хавсралт



ХОЙД БҮСИЙН АХМАДЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ”-Д ОРОЛЦОГЧДЫН ТӨСӨВ

д/д	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөгөөр)	Нийт үнэ (төгрөгөөр)
1	2	3	4	5
1	Дизель түлш	30	4,580	137,400
2	Автобус түрээс	1	200,000	200,000
3	Цэвэр ус (12ш)	3	18,000	72,000
4	Чуулганд оролцох албан хаагчдын томилолт	3	30,000	90,000
				499,400

--o00o--